НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 10 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

Нэрийн дансны 2025 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлсан "Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.28 хувиар баталсугай.

2.Батлсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тус тус хүү тооцох ажлыг 2026 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

ДАРГА Т.АУБАКИР

1119276367
5284708 СБА1473